

MONGOLIA

ЭКСПОРТЫН ЗЭЭЛИЙН ДААТГАЛ

ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛД ЭРСДЭЛГҮЙ ӨРСӨЛДӨХ ОНОВЧТОЙ ГАРЦ



ТАНЫГ ОЛОН УЛСАД ЗЭЭЛЭЭР ЭКСПОРТ
ХИЙЖ, ӨРСӨЛДӨХ ЧАДВАРАА НЭМЭГДҮҮЛЭХЭД
БИД ТУСАЛНА



ТАНЫ ГАДААД ХУДАЛДАН АВАГЧ
ТӨЛБӨРӨӨ ТӨЛӨХГҮЙ БАЙХ ЭРСДЛЭЭС
БИД ХАМГААЛНА



ТАНЫ ГАДААД ХУДАЛДАН АВАГЧИЙН
САНХҮҮ-ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭГ
БИД ХИЙНЭ

Mongolian Re

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ



ЭКСПОРТЫН ЗЭЭЛИЙН ДААТГАЛЫН АЧ ХОЛБОГДОЛ

- ✓ Олон улсын зах зээлд **ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ ЭРСДЭЛГҮЙГЭЭР НЭМЭГДҮҮЛНЭ**
- ✓ Гадаад худалдан авагч зээлээр худалдан авсан бүтээгдэхүүнийхээ **ТӨЛБӨРИЙГ ТӨЛӨХГҮЙ БАЙХ ЭРСДЛЭЭС БҮРЭН ХАМГААЛНА**
- ✓ Бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн цар хүрээг сайжруулснаар **ЗЭЭЛИЙН БАРЬЦАА ХӨРӨНГИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ**
- ✓ “Экспортын зээлийн даатгалын гэрээ”-г барьцаа хөрөнгө болгон арилжааны банк болон бусад санхүүгийн байгууллагуудаас **САНХҮҮЖИЛТ-ЗЭЭЛ АВАХ** боломжтой.
- ✓ Бид таны гадаад дахь **БИЗНЕСИЙН ТҮНШҮҮДИЙН САНХҮҮГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ**-г хамгийн үнэн зөв, бодитоор, түргэн шуурхай гаргаж өгнө.

“

ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛД БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГОО ЭРСДЭЛГҮЙГЭЭР НЭМНЭ.

Орчин цагт бүхий л бизнесийн үйлчилгээ, чанар сайжирч өрсөлдөгч хоорондын ялгаа багасаж байгаа нь өрсөлдөх шинэ арга барилыг биднээс шаардаж байна. Энэ хэрээрээ хязгаарлагдмал цөөн хүн амтай дотоодын худалдан авагчид хуваагдаж, бизнесийн ашиг орлого хумигдах сул талтай. Харин бид төлбөрийн уян хатан нөхцлийг санал болгосноор бараа бүтээгдэхүүнээ дэлхийн зах зээлд экспортлож бизнесээ өргөжүүлэх асар том боломж байна. ЭКСПОРТЫН ЗЭЭЛИЙН ДААТГАЛ танд энэ боломжийг бодит ажил хэрэг болгоход туслах болно.

**ЭКСПОРТЫН
ЗЭЭЛИЙН ДААТГАЛ** нь
таны гадаад дахь худалдан
авагч танаас зээлээр авсан
бараа бүтээгдэхүүнийхээ
төлбөрийг төлөөгүй
тохиолдолд учирсан
хохирлыг **НӨХӨН ТӨЛӨХ**
үйлчилгээ юм.

ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ
БАЙГУУЛЛАГААС “ХУДАЛДАН
АВАГЧ, ТҮНШҮҮДДЭЭ
БҮТЭЭГДЭХҮҮН
ҮЙЛЧИЛГЭЭГЭЭ ЗӨВХӨН БЭЛЭН
МӨНГӨӨР ХУДАЛДААЛСНААС
ИЛҮҮ ЗЭЭЛЭЭР ХУДАЛДАН
АВАХ НӨХЦӨЛИЙГ САНАЛ
БОЛГОВОЛ **ЭКСПОРТ
ДУНДЖААР 40%-ИАР ӨСДӨГ”**
ГЭЖ МЭДЭЭЛЖЭЭ.



ЭКСПОРТЫН ЗЭЭЛИЙН ДААТГАЛ ЯГ ЯМАР ЭРСДЛҮҮДЭЭС ХАМГААЛДАГ ВЭ?



ЭЗД НЬ АРИЛЖААНЫ ЭРСДЭЛ (ДАМПУУРАЛ Г.М.) БОЛОН УЛС ТӨРИЙН ЭРСДЭЛИЙГ (ДАЙН, МӨНГӨН ТЭМДЭГТ ХӨРВӨХ ЧАДВАРГҮЙ БОЛОХ Г.М.) ХОЁУЛАНГ НЬ ХАМАРДАГ. ЭДГЭЭРЭЭС БОЛЖ ГАДААД ХУДАЛДАН АВАГЧ ЗЭЭЛЭЭР ХУДАЛДАН АВСАН БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНИЙХЭЭ ТӨЛБӨРИЙГ ТӨЛӨХГҮЙ БАЙХ ЭРСДЛЭЭС ХАМГААЛАГДАХ БОЛНО.


АРИЛЖААНЫ ЭРСДЭЛ:

- ❌ Худалдан авагчийн бизнес дампуурах
- ❌ Худалдан авагч төлбөрийн чадваргүй болох
- ❌ Худалдан авагч ямар нэгэн шалтгаангүйгээр төлбөрөө төлөхгүй удаах

УЛС ТӨРИЙН ЭРСДЭЛ:

- ❌ Тухайн улсын засгийн газрын шийдвэрийн дагуу төлбөрийг зогсоох
- ❌ Валютын үл хөрвөх байдал үүсэх
- ❌ Худалдан авагч компанийг улсын мэдэлд авах, хөрөнгийг албадан хураах
- ❌ Экспорт, импортын лицензийг цуцлах, сунгахгүй байх, хүчингүй болгох
- ❌ Худалдан авагчийн оршин буй улсын Засгийн газраас бараа бүтээгдэхүүний хүргэлтийг хаах /хориг/, эсвэл ямар нэг байдлаар бизнес эрхлэхэд саад хийх
- ❌ Дайн, иргэний дайн, бослого үймээн самууны улмаас төлбөр төлөгдөхгүй байх, хойшлох

ЭКСПОРТЫН ЗЭЭЛИЙН ДААТГАЛ ХЭРХЭН ҮЙЛЧИЛДЭГ ВЭ?



ЗЭЭЛИЙН ХЯЗГААР, ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ, ЗЭЭЛЭЭР ОЛГОЖ БОЛОХ ДЭЭД ХЯЗГААРЫГ ТОГТООХДОО:

Таны тухайн гадаад харилцагчийг судалж, зээлээр бараагаа худалдах мөнгөн дүнгийн дээд хязгаарыг тогтоож, даатгалын үнэлгээг гаргах ба үүнд дараах зүйлсийг харгалзан үздэг.

- Таны бизнесийн үйл ажиллагаа явуулж буй улс орон
- Эрхэлж буй үйл ажиллагааны чиглэл, салбар
- Салбарын онцлог
- Санхүүгийн үзүүлэлт

Таны бараа бүтээгдэхүүнийг зээлээр худалдан авах гадаад дахь харилцагчид дүн шинжилгээ хийх, зээлийн хязгаарыг тогтоох, хянахдаа бид олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, салбартаа тэргүүлэгч 20 жилийн түүхтэй Тинүбү компанийн туршлагатай эрсдэлийн шинжээчидтэй хамтран ажилладаг.

Экспортлогч та гадаад дахь түншээрээ хэдэн ч харилцагчтай хамтран ажиллах боломжтой бөгөөд бид таны бараа бүтээгдэхүүн зээлдэгч харилцагч бүрийн эрсдлийн шинжилгээг хийж, худалдан авагч бүрт зээлийн хязгаарыг тогтоож өгнө. Энэхүү тогтоосон зээлийн хязгааруудын нийлбэр нь нийт даатгалын үнэлгээ байх ба даатгалын шимтгэл ердөө 0,5-1,5% байна.

Олон улсын тэргүүлэгч давхар даатгагч SCOR компанитай экспортын зээлийн давхар даатгалын гурвалсан гэрээг байгуулан хамтран ажиллаж байна. Таны гадаад худалдан авагч зээлээр авсан барааныхаа төлбөрийг төлөхгүй бол бид эрсдлийг үүрч өмнөөс нь танд тэрхүү төлбөрийг төлөх болно. Энэхүү эрсдэлийн 80%-ийг олон жилийн туршлагатай, дэлхийн тэргүүлэгч давхар даатгалын компани SCOR хариуцах тул та итгэл төгс экспортоо зээлийн нөхцлөөр хийгээрэй.



ЭРСДЭЛ ХУВААРИЛАЛТ





ТА ДАРААГИЙН АЛХМАА **ХИЙГЭЭРЭЙ!**

Та шинэ зах зээлд бүтээгдэхүүнээ борлуулж, эдийн засгийн асар том боломжийг ашиглахад бэлэн болсон бол бид танд тусалъя. Таны хэрэгцээнд нийцсэн санхүүгийн өргөн хүрээний туршлага зөвлөгөө мэдээ мэдээллээр бид таныг хангана.

ДААТГАЛЫН МЕНЕЖЕРТЭЙ ХОЛБОГДОРОЙ

Та Экспортын зээлийн даатгалын үйлчилгээний талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл зөвлөгөө авахыг хүсвэл Даатгалын менежертэй холбогдоорой.

☎ 7577 0002

✉ gantuya@mongolianre.com

ТА МАНАЙ ВЭБ ХУУДСААР ЗОЧЛОРОЙ

Та дараах QR кодоор манай вэб хуудасруу нэвтэрч ЭКСПОРТЫН ЗЭЭЛИЙН ДААТГАЛ-ын талаар бүх төрлийн мэдээллийг дэлгэрэнгүй авах боломжтой.



🌐 <http://mongolianre.com/>

ЦАХИМ ГАРЫН АВЛАГАТАЙ ТАНИЛЦААРАЙ

Энэхүү үнэгүй цахим гарын авлагаас та өөрт хэрэгтэй анхан шатны мэдээллүүдээ дэлгэрэнгүй авах боломжтой.

ТАТАХ ЛИНК: shorturl.at/byFH7

МАНАЙ СОШИАЛСУВГУУДЫГ ДАГААРАЙ

📘 <https://facebook.com/MongolianRe>

📷 <https://instagram.com/mongolianreinsurance>

📺 <https://youtube.com/@mongolianre6433>

🌐 <https://linkedin.com/company/mongolian-re/>

🐦 https://twitter.com/Mongolian_Re